

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 8.11.26 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны 2026 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хараат бус гишүүн Гэлэгжамцын Батжаргал нь хараат бус гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн тул хүсэлтийг хүлээн авч, энэхүү тогтоол гарсан өдрөөр хараат бус гишүүнээс чөлөөлсүгэй.
2. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг түр орлох холбогдох хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан этгээдийг сонгон шалгаруулж, ТУЗ-ийн хуралд танилцуулах, түр томилуулахыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо (Ж.Болормаа)-нд даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, холбогдох мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН



Ж.БОЛОРМАА